



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 28 өдөр

Дугаар А/179

Шивээговь сум

Хариуцлагатай жижүүр ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.10, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/383 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Шинэ жилийн баяр ёслолыг тэмдэглэн өнгөрүүлэхэд албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн харуул хамгаалалтын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах хариуцлагатай жижүүрийг 2023 оны 12 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг дуустал томилон ажиллуулсугай.

2.Хариуцлагатай жижүүрийн хуваарийг 1 дүгээр хавсралтаар, гүйцэтгэх үүргийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.


3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал), захирамжийн хэрэгжилтийг хангаж, хариуцлагатай жижүүрт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, удирдан зохион байгуулж, хяналт тавьж хамтран ажиллахыг Цагдаагийн хэсгийн дарга, Цагдаагийн дэд хурандаа (Б.Шинэбаяр) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА

Сумын Засаг даргын 2023 оны  
 12 сарын 28 өдрийн 11/139 дугаар  
 захирамжийн 1-р хавсралт



### Хариуцлагатай жижүүрийн хуваарь

2023.12.28.

№	Байгууллага, албан тушаалтан	Овог нэр	Утас	Он, сар, өдөр	Цагийн хуваарь
1.	Ерөнхий боловсролын сургуулийн захирал	Д.Буяндэлгэр	99906850	2023.12.29	18 <sup>00</sup> – 21 <sup>00</sup>
2.	ШОХК хүний нөөцийн хэлтсийн дарга	Ч.Энхжаргал	99072011		21 <sup>00</sup> – 24 <sup>00</sup>
3.	Эрүүл мэндийн төвийн дарга	П.Ганчимэг	99035552	2023.12.30	18 <sup>00</sup> – 21 <sup>00</sup>
4.	“Шивээ Сервис” ХХК-ийн захирал	Ж.Чинбат	99186124		21 <sup>00</sup> – 24 <sup>00</sup>
5.	Засаг даргын Тамгын газрын дарга	Д.Отгонжаргал	88116503	2023.12.31	18 <sup>00</sup> – 21 <sup>00</sup>
6.	Соёлын төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Г.Гансүлд	99283933		21 <sup>00</sup> – 24 <sup>00</sup>
8.	3-р цэцэрлэгийн эрхлэгч	Б.Даваадолгор	96663805	2023.01.01	18 <sup>00</sup> – 21 <sup>00</sup>
9.	“Илчлэг Шивээ” ААТҮГ-ын дарга	Ш.Чинболд	96056446		21 <sup>00</sup> – 24 <sup>00</sup>

**Жич:** Засаг даргын Тамгын газрын дарга сумын цагдаагийн хэсэгтэй хамтран хариуцлагатай жижүүрийн хуваарьт өдөр бүр хяналт тавьж ажиллах.

Сумын Засаг даргын 2023 оны  
12 сарын 28 өдрийн А/179 тоот  
захирамжийн 2-р хавсралт



### **Сумын хариуцлагатай жижүүрийн үүрэг гүйцэтгэх удирдах албан тушаалтнуудын үүрэг**

1. Томилогдсон хариуцлагатай жижүүрүүд 2023 оны 12 дугаар сарын 29-ний өдрөөс 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрүүдэд 18:00 цагаас 24:00 цагийн хооронд хуваарилагдсан цагтаа үүрэг гүйцэтгэнэ.
2. Томилогдсон хариуцлагатай жижүүр нь үүрэг гүйцэтгэх цагаас 10 минутын өмнө ирж өмнөх жижүүрээс гарын үсэг зуран ажлаа хүлээн авна.
3. Хариуцлагатай жижүүрүүд утас нээлттэй байлгах, байгууллагуудтай биечлэн танилцаж үүрэг, зөвлөмж өгч холбогдох албан тушаалтан, удирдлагуудад цаг тухайд нь танилцуулж зохих арга хэмжээ авч ажиллана.
4. Хариуцлагатай жижүүрүүд хуваарийн дагуу гарч эргүүл, шалгалтын ажлыг чанартай гүйцэтгэн мэдээллийг нэгтгэн сумын Засаг даргын Тамгын газар болон цагдаагийн хэсэгт албан ёсоор илтгэх хуудас бичиж дараагийн жижүүрт хүлээлгэн өгнө.
5. Цаг үеийн байдлыг сумын Засаг Даргын Тамгын газрын дарга Д.Отгонжаргал 88116503 дугаарт холбогдож мэдээлэл өгч ажиллана.

### **Шаардлагатай утасны жагсаалт:**

Засаг даргын Тамгын газар - 70546809

ЗДТГ-ын Дарга – 88116503

Эрүүл мэндийн төв- 99035552

Ерөнхий боловсролын сургууль – 99906850

3-р цэцэрлэг – 96663805

“Илчлэг Шивээ” ААТҮГ – 95246417

Цагдаагийн хэсэг - 99595934